



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ДОЛОО ДУГААР ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 30

Мөрөн сум

Хоршоог хөгжүүлэх сангийн
төсөл сонгон шалгаруулах хороо,
хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361, 2023 оны А/521 дүгээр тушаалыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Долоодугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хоршоог хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, хяналт тавих үүрэг бүхий хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Холбогдох хууль тогтоомж, заавар журмыг хэрэгжүүлж ажиллахыг хорооны дарга (Н.Намжилноров)-д, сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хуульд заасан хугацаанд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Н.Хатанбаатар)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжлтэнд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, дэд бүтцийн хөгжлийн хороо (Г.Дашпүрэв)-нд даалгасугай.

4. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 17, 18-р тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн Долоодугаар
хуралдааны ...30...-р тогтоолын нэгдүгээр хавсралт



Хоршоог хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах

Чиг үүрэг бүхий хорооны бүрэлдэхүүн

Хорооны дарга: Засаг Даргын Тамгын Газрын Дарга

Нарийн бичгийн дарга: Хүнс, ЖДҮ, Хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Ерөнхий нягтлан бодогч

Эмэгтэйчүүдийн холбооны гишүүн Б.Баянсувд

Ахмадын холбооны гишүүн Г.Уранчимэг

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн Долоодугаар
хуралдааны ...30...-р тогтоолын Хоёрдугаар хавсралт



Хяналт тавих үүрэг бүхий Зөвлөлийн бүрэлдэхүүн

Хяналтын зөвлөлийн дарга: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Г.Дашпүрэв

Нарийн бичгийн дарга: Хүнс, ЖДҮ, Хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн

Хэнтий аймгийн ЖДҮ, Хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн

ТББ-ын төлөөлөл Д.Пүрэвжаргал